

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2024 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

№ 24/01

Улаанбаатар хот

**Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны  
тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай**

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалт болон 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Компанийн ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ





**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2024 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

№ 24/02

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн  
гишүүдийг сонгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах заалт, 77 дугаар зүйлийн 77.1, 77.2 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг болон 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр дараах нэр дэвшигчдийг сонгосугай.
  - 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн гишүүн:
    - 1.1.1. Монгол Улсын иргэн Очирсүрэн овогтой Болдбаатар
    - 1.1.2. Монгол Улсын иргэн Цэрэндорж овогтой Ууганбаяр
    - 1.1.3. Монгол Улсын иргэн Баатархүү овогтой Хос-Эрдэнэ
    - 1.1.4. Япон Улсын иргэн Кацужинко Мадано
    - 1.1.5. Монгол Улсын иргэн Цэвэгжав овогтой Одмаа
    - 1.1.6. Монгол Улсын иргэн Сэнгээ овогтой Энх-Амгалан
  - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн:
    - 1.2.1. Монгол Улсын иргэн Жигдэн овогтой Жаргалсүрэн
    - 1.2.2. Монгол Улсын иргэн Сүрэнхүү овогтой Боргил
    - 1.2.3. Монгол Улсын иргэн Сандагжав овогтой Нэргүй
2. Компанийн дүрмийн 9.3-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 1 (нэг) жил буюу дараа жилийн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл үргэлжлэхийг дурдсугай.
3. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад Компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн болон Хараат бус гишүүдэд үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ДАРГА





**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2024 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

№ 24/03

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны төсвийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.11 дэх заалт болон 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралтад заасны дагуу баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ДАРГА



О.БОЛДБААТАР



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн  
2024 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит хурлын  
24/03 тоот шийдвэрийн Нэгдүгээр ХАВСРАЛТ



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТӨСӨВ**

No	Зардлын зүйл	Гишүүдийн тоо	Сарын цалин (төгрөг)	Сар	Нийт төсөв (төгрөг)
<b>1</b>	<b>Цалин урамшууллын төсөв</b>	<b>10</b>	<b>13,780,000</b>	<b>12</b>	<b>186,030,000</b>
1.1	Дарга	1	1,950,000	12	23,400,000
1.2	Хорооны дарга	3	1,560,000	12	56,160,000
1.3	Гишүүн	5	1,300,000	12	78,000,000
1.4	Нарийн бичгийн дарга	1	650,000	12	7,800,000
1.5	НДШ-ийн зардал				20,670,000
<b>2</b>	<b>Хурал болон бусад зардал</b>				<b>10,000,000</b>
	<b>НИЙТ ТӨСӨВ</b>				<b>196,030,000</b>



